

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН  
АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ШУДАРГА ЁС, ИЛ ТОД БАЙДЛЫГ  
ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2018 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ТАЙЛАН

12/25/2018

№	Эрх зүйн үндэслэл	Хэрэгжүүлэх арга зам	Гүйцэтгэл
1	2	3	4
<b>Нэг. Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах чиглэлээр:</b>			
1.1.		2018 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр нийтэд мэдээллэх	Орон нутгийн өмчийн газрын 2018 онд зохион байгуулах худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Монголын үнэн сонины 2017 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн №246 дугаарт нийтэлсэн.
1.2.		Тендер шалгаруулалтын журам, заавар, мэдээллийг олон нийтэд мэдээллэх	Улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тендер шалгаруулалтын журмыг хуулийн дагуу сонгож Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> , Монголын үнэн сонин болон худалдан авах ажиллагааны мэдээллийн самбарт байршуулсан болно. Мөн орон нутгийн өмчийн газрын <a href="http://www.umch.khs.gov.mn">www.umch.khs.gov.mn</a> цахим сайтыг ажиллуулж, өнөөдрийн байдлаар 216239 хүн хандаж мэдээлэл авсан байна. <a href="http://www.umch.khs.gov.mn">www.umch.khs.gov.mn</a> цахим сайтад худалдан авах ажиллагаа болон өмчийн бүртгэл, хяналттай холбоотой хууль, эрх зүйн актыг нийтэлсэн.
1.3.		Тендерийн урилга, зарлал, үр дүн, явцын мэдээллийг мэдээллийн самбар, холбогдох цахим сайтуудад байршуулах	Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> сайтад Төсвийн ерөнхийлөн захирагчийн 1483 (давхардсан тоогоор) тендерийн урилга, зарлалыг /Үүнээс: ОНӨГ 507 тендерийн урилга (давхардсан тоогоор)/, Мэдээллийн самбарт ОНӨГ-аас зарласан 507 тендерийн урилгыг мэдээллийн самбарт байршуулсан, Монголын үнэн сонинд нээлттэй тендер, зөвлөх үйлчилгээний 102 тендерийн урилга, зарлалыг нийтэлсэн. Худалдан авах ажиллагааны үр дүн, тендер шалгаруулалтын явц зэргийг <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> , <a href="http://www.shilendans.gov.mn">www.shilendans.gov.mn</a> сайтуудад тухай бүр нийтэлсэн. Улс болон аймгийн хөрөнгө оруулалтын зардлаар хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүн, гүйцэтгэлийн мэдээллийг <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> , <a href="http://www.shilendans.gov.mn">www.shilendans.gov.mn</a> цахим сайтуудад тухай бүр, захиалгаар худалдан авах ажиллагаа зохион байгуулахаар ирүүлсэн худалдан авах ажиллагааны үр дүн, явцыг худалдан авах ажиллагааны үр дүн, явцыг <a href="http://www.shilendans.gov.mn">www.shilendans.gov.mn</a> оруулах тухай ОНӨГ-ын зөвлөмжид хүргүүлж хэвшсэн.
1.4.		Үнэлгээний хороонд ажиллах ТББ, ИНБ, иргэний төлөөллийг аймгийн ИТХ-ын саналыг авах	2018 онд зохион байгуулах худалдан авах ажиллагааны үнэлгээнд хороонд ажиллах ТББ, ИНБ, иргэний төлөөллийг нэрсийн саналыг авахаар ОНӨГ-ын даргын 2018 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн 1/01 тоот албан бичгийг Аймгийн ИТХ-д хүргүүлсэн.

1.5.		Худалдан авах ажиллагааны аймгийн болон газрын тайланг олон нийтэд мэдээллэх, холбогдох эрх бүхий байгууллагад тайлагнах	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2018 онд аймгийн Засаг даргад нийт 11084,0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 22 төсөл, арга хэмжээний эрх шилжиж ирсэн. БСШУСЯам, ЗГХЭГ, ЭМЯ, ХХААХҮЯ, ХНХЯ-нд улирал бүр тайлагнасан. Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газрын www.umch.khs.gov.mn цахим сайтад 216239 хүн хандаж мэдээлэл авсан байна. Манай байгууллагын үзүүлж буй төрийн үйлчилгээ, үйл ажиллагааны талаар 75,3 хувь нь сайн, 20,0 хувь нь дунд, 3,2 хувь нь муу, 1,5 хувь нь үнэлж мэдэхгүй байна гэсэн байна
1.6.	1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ	Худалдан авах ажиллагааны үр дүн, явцын талаар брошур, танилцуулга бэлтгэж тараах	“Төрийн худалдан авах ажиллагаа-Өмчийн удирдлага 2018” нээлттэй өдөрлөгт зориулан байгууллагын үйл ажиллагааг сурталчилсан 150 ширхэг танилцуулах хуудсыг бэлтгэж тараасан.
1.7.	худалдан авах тухай хууль, 2. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, 3. Авлигын эсрэг хууль, 4. Шилэн дансны тухай хууль 5. Нийтийн сонсголын тухай хууль	Цахим худалдан авах ажиллагааны сургалтыг зохион байгуулах	2018 оны 03 дугаар сарын 22-ны өдөр төсөвт байгууллагын дарга, эрхлэгч, нягтлан бодогч-9, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн төлөөлөл-68 нийт 77 хүн, 2018 оны 4 дугаар сарын 20-ны өдөр аймгийн удирдах ажилтны зөвөлгөөнд оролцсон сумын Засаг дарга, ИТХ-ын дарга, төсөвт байгууллагын дарга, эрхлэгч, ОНӨ-т аж ахуйн нэгжийн захирал удирдлага нийт 185 хүн, 2018 оны 06 сарын 18-ны өдөр Галт суманд зохион байгуулсан Галт санаачлага-2018 сумдын ИТХ-ын дарга, нарийн бичгийн дарга, сумын ИТХ-ын төлөөлөгчид, Тэргүүлэгчид, багийн ИНХ-ын дарга нар нийт 188 хүн, нийт 450 хүн худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиглэлээр сургалт зөвлөгөө өгч худалдан авах ажиллагааны суурь мэдлэг олгодог
1.8.		А-3 сертификатын сургалтыг зохион байгуулах	МУИС-ийн харъяа худалдан авах ажиллагааны сургалт, мэдээлэл өгөх төвийн багш Жавхлантай гэрээ байгуулан худалдан авах ажиллагааны суурь мэдлэг олгох А-3 сертификатын сургалтыг 2018 оны 01 дүгээр сарын 8-ны өдрөөс 11 хүртэл 3 хонгийн хугацаанд мөрөн суманд зохион байгуулж нийт 193 хүнд сургалт өгч, 115 хүн худалдан авах ажиллагааны А-3 сертификат олгосон байна
1.9.		Тендерийн нээлтэнд орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагыг оролцуулах	Монголын үндэсний телевизээр "50 100 цогцолбор"-ын тухай нэвтрүүлгээр олон нийтэд мэдээлсэн. Мөн тендерийн нээлтэд орон нутгийн теледизүүд тогтмол оролцож олон нийтэд мэдээлсэн.
1.10.		Төрийн бус байгууллага, Иргэний нийгмийн байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулах	Орон нутгийн "Үзэсгэлэнт мөрөн"ХХК буюу мөрөн телевизтэй, "Өсөх прогресс"ХХК буюу Хөвсгөл телевизтэй, Хөвсгөл аймгийн "Үйлдвэрчний эвлэлийн холбоо"-той, "Хөвсгөл далай ээж нийгэмлэг"ТББ-тай, Хөвсгөл аймаг дахь "Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг" ТББ-тай, Монголын Худалдаа аж үйлдвэрийн танхимын Хөвсгөл аймаг дахь салбартай, "Сайн засаглалыг дэмжигч иргэдийн оролцоо"ТББ-тай, "Монголын үнэн сонин"ХХК-тай, Хөвсгөл аймгийн "Инженерүүдийн холбоо"ТББ-тай тус тус байгуулан ажиллаж байна

1.11.	Аймгийн ИТХ-ын 2013 оны 43 дугаар тогтоолоор баталсан журамд нэмэлт, өөрчлөлт оруулах	Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 43 дугаар тогтоолоор баталсан "Худалдан авах ажиллагааны журам"-нд нэмэлт, өөрчлөлтийг төслийг боловсруулж байгаа. Аймгийн Засаг даргын зөвлөлөөр оруулж хэлэлцүүлнэ.
1.12.	2017 оны худалдан авах ажиллагааны үр дүн, гүйцэтгэлийг танилцуулах, 2018 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн баримт бичгийн шаардлага, нөхцлийг олон нийтээр хэлэлцүүлэх, нийтийн сонсгол хийх	2018 онд улс болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтын гүйцэтгэгч шалгаруулах тендерийн баримт бичгийн төслийг боловсруулж хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Урсгал зардлын хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний тендерийн баримт бичгийн төслийг 2017 оны 12 дугаар сарын 21-ний өдөр аймгийн ЗДТГ-ын "Сүлд" танхимд захиалагч байгууллага /сургууль, цэцэрлэг, бусад төсөвт байгууллага/, Төрийн бус байгууллага, Иргэний нийгмийн байгууллага, тендерт оролцогч байгууллагын төлөөлөл нийт 56 хүн, хөрөнгө оруулалтын зардлаар хэрэгжих төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч шалгаруулах тендерийн баримт бичгийн төслийн хэлэлцүүлгийг 2018 оны 3 дугаар сарын 22-ны өдөр аймгийн ЗДТГ-ын "Соёмбо" танхимд захиалагч байгууллага, аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, Мэргэжлийн хяналтын газар, "Хөвсгөл ус суваг" ХХК, Төрийн бус байгууллага, Иргэний нийгмийн байгууллага, иргэний төлөөлөл, тендерт оролцогч байгууллагын төлөөлөл нийт 76 хүн оролцож тендерийн баримт бичгийн төслийг баталсан.
<b>Хоёр. Өмчийн ил тод байдлын чиглэлээр:</b>		
2.1.	Өмчийн харилцаатай холбоотой дүрэм, журмыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх, цахим сайтуудад байршуулах	Өмчийн харилцааг зохицуулах аймгийн ИТХТ-ийн тогтоолоор батлагдсан "Хөрөнгийн харилцааны журам", "Дуудлага худалдааны журам" "Орон нутгийн өмчийг түрээсээр эзэмшүүлэх журам", "Орон нутгийн өмчит компанийн ТУЗ-ийн ажиллах нийтлэг журам" болон компаниудын дүрмийг батлагдсан тухай бүрт нь Орон нутгийн өмчийн газрын <a href="http://www.umch.khs.gov.mn">www.umch.khs.gov.mn</a> цахим сайтад нийтэлсэн.
2.2.	Өмчтэй холбоотой аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг дарга, Орон нутгийн өмчийн газраас гаргасан тогтоол, шийдвэрийг хэвлэл мэдээлэл, цахим сайтуудад байршуулах	Өмчийн харилцааны чиглэлээр 2018 онд аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс гарсан 42 тогтоол, Засаг даргын 18 захирамжийг Орон нутгийн өмчийн газрын <a href="http://umch.khs.gov.mn">umch.khs.gov.mn</a> сайтын Хууль, эрх зүй цэсний ОНӨ-ийн тогтоол, журам зааврууд хэсэгт нийтэлсэн. Орон нутгийн өмчийн газрын даргаас гаргасан тушаалыг дээрх сайтын Ил тод байдал цэсний газрын даргын тушаал хэсэгт байршуулсан.
2.3.	Аймгийн Өмчийн бүртгэл, хяналтын тайланг олон нийтэд ил тод болгох	Орон нутгийн өмчит 234 хуулийн этгээдийн 2017 оны жилийн эцсийн өмчийн тайлан мэдээг нэгтгэж, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлж, <a href="http://www.umch.khs.gov.mn">www.umch.khs.gov.mn</a> сайтад байршуулсан.

2.4.	1. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, 2. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, 3. Авлигын эсрэг хууль, 4. Нийтийн сонсголын тухай хууль	ОНӨҮГ, ОНӨХК-ийн ТУЗ, гүйцэтгэх удирдлага, хараат бус гишүүний сонгон шалгаруулалтыг олон нийтэд ил тод болгох	Орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой компаниудын ТУЗ-ийг томилсон шийдвэрийг umch.khs.gov.mn сайтад, "Хөвсгөл Эрчим Хүч" ХХК, "Хөвсгөл Ус Сувар" ХХК, "Шинэ Мөрөн худалдааны төв" ХК-ийн хараат бус гишүүд болон "Их-Уул Дулаан" ХХК, "Түнэл-Илч" ХХК-ийн гүйцэтгэх захирлын сонгон шалгаруулалтын зар мэдээг орон нутгийн "Эрх чөлөө" сонин, "Галт Дулаан" ХХК-ийн гүйцэтгэх захирлын сонгон шалгаруулалтын зарыг "Далай ээж" сонин болон umch.khs.gov.mn сайтад нийтэлж, иргэдэд ил тод мэдээлж ажиллав.
2.5.		Төрийн болон орон нутгийн өмчийг худалдан борлуулах дуудлага худалдааг олон нийтэд ил тод болгох	Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017-12-25-ны өдрийн 156 дугаар тогтоол, 2018 оны 56, 123, 133 дугаар тогтоолоор орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эзэмшиж буй 58 хөрөнгийг /дахин үнэлж зарласантай нийлээд/ худалдах тухай шийдвэр гарсан бөгөөд 4 удаагийн нээлттэй дуудлага худалдааны зар мэдээг орон нутгийн "Эрх чөлөө" сонин, Мөрөн телевиз, Орон нутгийн өмчийн газрын umch.khs.gov.mn сайтуудад тухай бүр байршуулан олон нийтэд ил тод нээлттэй мэдээлж, иргэдийн оролцох тэгш боломжийг ханган ажиллаж байна
2.6.		Төрийн бус байгууллага, Иргэний нийгмийн байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулах	Худалдан авах ажиллагааны сургалт, зөвлөгөөний төв ТББ, аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбоо, Мобинет ХХК, Худалдаа аж үйлдвэрийн танхим зэрэг байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулсан.
2.7.		Төрийн байгууллагын үйл ажиллагаа, бүтэц, чиг үүрэг, тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, улирал тутмын үйл ажиллагааны тайлан, ажилтнуудын хариуцсан үйл ажиллагааны чиг үүргийг ил тод, нээлттэй болгох	Хэлтсийн үйл ажиллагааны төлөвлөгөө, түүний хэрэгжилтийг хагас жилээр гарган, холбогдох байгууллагуудад хүргүүлж, хэлтэс болон ажилтнуудын чиг үүрэг, холбогдох утсыг байгууллагын самбар, сайтан дээр байршуулж байна.
2.8.		ОНӨААН-үүдийн үйл ажиллагаа, бүтэц орон тоо, санхүүгийн мэдээллийг ил тод, нээлттэй болгох	Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн 2018 оны эдийн засгийн зорилтот түвшинг umch.khs.gov.mn сайтад нийтэлж, орон нутгийн өмчит компаниудын хагас жилийн санхүү, эдийн засгийн үзүүлэлтийг нэгтгэн аймгийн Аудитын газарт хүргүүлж, байгууллагын самбар дээр байршуулан ажиллаж байна. Мөн <a href="http://shilendans.gov.mn">http://shilendans.gov.mn</a> сайтад төсөв, санхүүгийн мэдээлэл, гүйцэтгэлийг оруулах чиглэл өгч ажиллаж байна
<b>Гурав. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр:</b>			
3.1.		Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга хэлтсийн дарга, мэргэжилтнүүдтэй авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж, хариуцлагыг сайжруулах БАТЛАМЖ байгуулах	Газрын дарга Б.Болд ньХудалдан авах ажиллагааны хэлтсийн дарга А.Цэрэндулам, ахлах мэргэжилтэн З.Гал-Эрдэнэ, мэргэжилтэн З.Батбаяр, Ц.Эрдэнэбаатар, Ц.Дэлгэр, Өмчийн хэлтсийн дарга Н.Шинэбаяр, мэргэжилтэн Ц.Бэхбаяр, Ч.Лхагвамядаг, нягтлан бодогч Ц.Бямбажав, нярав-жолооч С.Эрдэнэбат нартай 2018 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр, 2018 оны 5 дугаар сарын 20-ны өдөр нягтлан бодогч Ш.Отгончимэгтэй "Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж, хариуцлагыг сайжруулах тухай" БАТЛАМЖ ГЭРЭЭ-г байгуулсан

3.2.	1. Нийтийн болон хувийн ашиг сонирхлын зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль,	Үнэлгээний хорооны гишүүнээр ажиллаж буй төрийн болон төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөгчдөөс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл-ийг бөглүүлэх	Худалдан авах ажиллагааны үнэлгээний хороонд ажилласан ТББ, ИНБ болон төрийн албан хаагчдаас тухай бүр "Ашиг сонирхлын зөрчилгүй, зөрчил үүссэн тухай мэдэгдэл"-ийг гаргуулан авсан. Өнөөдрийн байдлаар ТББ, ИНБ, төрийн албан хаагчдаас 990 хүнээс "Ашиг сонирхлын зөрчилгүй, зөрчил үүссэн тухай мэдэгдэл"-ийг гаргуулан Авлигатай тэмцэх газрын <a href="https://meduuleg.iaac.mn/AOS/">https://meduuleg.iaac.mn/AOS/</a> цахис системд шивж, тайлагнасан байна. 2018 оны эхний 11 сарын байдлаар Авлигатай тэмцэх газрын <a href="https://meduuleg.iaac.mn/AOS/">tps://meduuleg.iaac.mn/AOS/</a> цахис системд 1194 мэдэгдэл тайлбарыг шивж тайлагнасан байна
3.3.		Төсөл арга хэмжээний гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулсан эрх бүхий албан тушаалтнуудаас ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл-ийг бөглүүлэх, АТГ-ын сайтад шивэх	Төсөл, арга хэмжээний хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж буй улс төрийн болон төрийн албан хаагчдаас "Ашиг сонирхлын зөрчилгүй, зөрчил үүссэн тухай мэдэгдэл"-ийг гаргуулан авч хэвшсэн. Өнөөдрийн байдлаар 186 мэдэгдэл тайлбарыг авч тэмцэх газрын <a href="https://meduuleg.iaac.mn/AOS/">https://meduuleg.iaac.mn/AOS/</a> цахис системд шивж, тайлагнасан байна.
3.4.		Тендерийн баримт бичигт үнэлгээний хорооны гишүүнд нөлөөлсөн, нөлөөлөхийг оролдсон тохиолдолд тухайн тендерт оролцогчид холбогдох арга хэмжээг авч, тендерээс татгалзах тухай тусгах	2015 оноос хойш зохион байгуулсан худалдан авах ажиллагааны тендерийн баримт бичигт Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх заалтад заасан нөхцөл байхгүйг бичгээр мэдэгдэх тухай тусгаж хэвшсэн. Мөн Тендерийн баримт бичигт тендерт оролцогч нь үнэлгээний хорооны гишүүдэд нөлөөлөх, нөлөөлөхийг оролдсон нь баримтаар нотлогдвол тендерээс татгалзах тухай тусгаж хэвшсэн
<b>Дөрөв. Тайлагнал</b>			
4.1.		Эрх бүхий албан тушаалтнуудаас Албан тушаалтны 2017 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг авч АТГ-ын сайтад шивэх, аймгийн ЗДТГ-ын ХЗХ-т хүргүүлэх	Орон нутгийн өмчийн газрын дарга Б.Болд 2017 оны "Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг"-ээ 2018 оны 02 сарын 01-ний өдөр Авлигатай тэмцэх газрын сайтад шивж оруулсан, Худалдан авах ажиллагааны хэлтсийн дарга А.Цэрэндулам 2017 оны "Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг"-ээ 2018 оны 01 сарын 31-ний өдөр Авлигатай тэмцэх газрын сайтад шивж оруулсан, Өмчийн хэлтсийн дарга Н.Шинэбаяр 2017 оны "Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг"-ээ 2018 оны 02 сарын 06-ны өдөр Авлигатай тэмцэх газрын сайтад шивж оруулсан, Худалдан авах ажиллагааны хэлтсийн ахлах мэргэжилтэн З.Гал-Эрдэнэ 2017 оны "Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг"-ээ 2018 оны 02 сарын 02-ны өдөр Авлигатай тэмцэх газрын сайтад шивж оруулан тайлагнасан байна. Байгууллагын 2017 оны оны ХАСХОМ-1, ХАСХОМ-2, ХАСХОМ-3, ХАСХОМ-4 тайланг аймгийн ЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтэст Орон нутгийн өмчийн газрын 2018 оны 03 сарын 01-ний өдрийн 1/196 тоот албан бичгээр хүргүүлсэн.

4.2.		2018 оны худалдан авах ажиллагааны ил тод байдал, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлсэн талаар тайланг МУ-ын Авлигтай тэмцэх газар, аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ-т хүргүүлэх	Аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэс болон Хөвсгөл аймгийн авлигаас урьдчилан сэргийлэх иргэний хяналтын зөвлөлд 2018 оны худалдан авах ажиллагааны ил тод байдал, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлсэн талаар авч хэрэгжүүлсэн тайланг боловсруулан хүргүүлэхээр бэлдэж байна.
4.3.		Байгууллагын тухайн жилийн төсөв түүнтэй холбоотой мэдээллийг ил тод болгох	Байгууллагын <a href="http://www.umch.khs.gov.mn">www.umch.khs.gov.mn</a> сайтад байгууллагын үйл ажиллагаа, тендерийн урилга, төлөвлөгөө, гүйцэтгэл, үр дүн, байгууллагын бүтэц орон тоо, өмчийн дуудлага худалдааны зарлал, өмчийн тайлан мэдээ, худалдан авах ажиллагааны ил тод байдал, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөг зэргийг багтаасан. Мөн өмчийн хэлтэс болон худалдан авах ажиллагааны хэлтэс нь өдөр тутмын мэдээллээ оруулж хэвшсэн. Байгууллагын цахим сайтаас одоогийн байдлаар 216239 хүн хандаж мэдээлэл авсан байна. Худалдан авах ажиллагааны урилга, үр дүн, төлөвлөгөө, тайлан болон өмч хөрөнгийн дуудлага худалдаа, өмчийн бүртгэл хяналт, байгууллагын төсөвтэй холбоотой мэдээллийг тогтмол нийтэлж байна.
4.4.		Байгууллагын хүний нөөц, үйл ажиллагаа, санхүүгийн мэдээлэл, мөн худалдан авах ажиллагааны урилга, үр дүн, төлөвлөгөө, тайлагналт, өмчийн бүртгэл хяналт, дуудлага худалдаа, тайланг байгууллагын мэдээллийн самбар, ил тод байдлын мэдээллийн самбарт тухай бүр нийтлэх	Байгууллагын 2018 оны төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг мэдээллийн самбар болон <a href="http://www.shilendans.gov.mn">www.shilendans.gov.mn</a> <a href="http://www.umch.khs.mn">www.umch.khs.mn</a> цахим сайтуудад тухай бүр нийтэлж хэвшсэн. Мэдээллийн самбарт байгууллагын төсвийн зарцуулалт, гүйцэтгэлийг иргэд ойлгохоор байршуулж байгаа.
4.5.		Байгууллагын дотоод хяналтын нэгжийн ажиллах журмыг шинэчлэх	Дотоод хяналтын нэгжийн ажиллах журмыг боловсруулан газрын даргаар батлуулан мөрдөн ажиллаж байна.
4.6.		Байгууллагын дотоод хяналтын нэгжийн 2018 онд ажиллах төлөвлөгөөг боловсруулах	Байгууллагын дотоод хяналтын нэгжийн 2018 оны төлөвлөгөөг 2018 оны 2 дугаар сарын 23-ны өдөр газрын даргаар батлуулан ажиллаж байна.
4.7.	1. Нийтийн болон хувийн ашиг сонирхлын зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль,	Байгууллагын албан хаагч бүрээс авлига ашиг сонирхлын урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг хангаж ажилласан тухай тайлан авах	Худалдан авах ажиллагааг 100 хувь цахим болгох, худалдан авах ажиллагааг ил тод нээлттэй болгох талаар Аймгийн Засаг даргын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 17 дугаар албан даалгавраар сум, байгууллагын дарга нарт үүрэг болгосон. Уг албан даалгаврын хэрэгжилтийг 2018 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор авч, биелэлтийг тооцож, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар оруулан тайлагнана.
4.8.		Байгууллагын албан хаагчдын ажлын цаг ашиглалтыг сайжруулах, хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх	Ажлын цагийн бүртгэлийг нярав-жолооч С.Эрдэнэбат өдөр бүр албан хаагчдын цагийг бүртгэж, нягтлан бодогчид хянуулдаг.

4.9.	Байгууллагын 2017 оны тайланг Засаг даргын зөвлөлийн хурал, ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралд тайлагнах, дүгнүүлэх	Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар баталсан худалдан авах ажиллагааг тайлагнах журмын дагуу төрийн байгууллага, орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн худалдан авах ажиллагааны хэрэгжилтэнд Санхүү, хяналт, дотоод аудитын алба, Орон нутгийн өмчийн газар, аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээнийн хэлтэс үнэлгээ хийж Сангийн яаманд нэгтгэн хүргүүлдэг болсон ба аймгийн ТЭЗ-ийн 2017 оны худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд Сангийн яам 96,8 хувийн хэрэгжилттэй "маш сайн" гэсэн үнэлгээ өгч, Монгол улсад тэргүүлсэн амжилт гаргасан байна /Сангийн сайдын 2018.03.22-ны өдрийн 6-1/1425 тоот албан бичгийг ирүүлсэн/. Мөн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын 2018 оны 4 сарын 19 -ны өдрийн А/61 дүгээр тогтоолоор Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагааг 99,7 хувьтай буюу "Хяналттай сайн" гэж дүгнэсэн.
4.10.	2018 оны худалдан авах ажиллагааны хагас жилийн үр дүн, гүйцэтгэлийн тайланг Засаг даргын зөвлөлийн хурал, ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралд тайлагнах, дүгнүүлэх	Худалдан авах ажиллагааны явц, гүйцэтгэл, хөрөнгө оруулалтын хэрэгжилтийн талаар аймгийн Засаг даргын 2018 оны .. Сарын ...-ны өдрийн ... Дугаар хурал, ... Сарын ...-ны өдрийн ... Дугаар хурлаар тус тус оруулан тайлагнасан. 2018 оны худалдан авах ажиллагааны гүйцэтгэл, үр дүнг хугацаа 2018 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор аймгийн Засаг даргын зөвлөл болон ИТХ-ын Тэргүүлэгчдэд тайлагна.
4.11.	Байгууллагын нууцын журам боловсруулж, батлуулах	Байгууллагын нууцын жагсаалтыг боловсруулан аймгийн Тагнуулын хэлтэст танилцуулсан. Тагнуулын байгууллагаас цахим сүлжээний мэдээллийн нууцлалтай холбоотой шалгалт хийж "их эрсдэлтэй" гэсэн тайланг /Тагнуулын ерөнхий газрын Хөвсгөл аймаг дахь хэлтсийн 2018.10.26-ны өдрийн 32/80 тоот албан бичгээр/ ирүүлсэн. Тагнуулын байгууллагаас ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэхээр төлөвлөгөө боловсруулан мөрдөн ажиллаж байна.
4.12.	Нийтийн болон хувийн ашиг сонирхлын зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг тухай хууль, Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах тухай хуулиар байгууллагын ажилчдад сургалт орох	2018 оны 6 дугаар сарын 18-ны өдөр ОНӨГ-ын албан хаагчдад авлигаас урьдчилан сэргийлэх талаар сургалтыг Худалдан авах ажиллагааны ахлах мэргэжилтэн, ОНӨГ-ын эрх бүхий албан тушаалтан З.Гал-Эрдэнэ хийсэн. Мөн ОНӨГ-ын дарга Б.Болд Авлигатай тэмцэх газрын сургалтанд хамрагдаж, уг сургалтыг байгууллагын албан хаагчдад 2018 оны 9 сарын 14-ний өдөр хийсэн.

4.13.	Байгууллагын нэрэмжит нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулах	<p>Төрийн худалдан авах ажиллагааны Өмчийн удирдлын 2018-10-24-ний өдөрлөгийг аймгийн Орон нутгийн өмчийн газрын хамт олон аймгийн ИТХ, Эрчим хүчний зохицуулах зөвлөл, орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой компаниудын ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нартай хамтран 2018 оны 09 дүгээр сарын 07-08-ны өдрүүдэд Чингүнжавын талбайд зохион байгууллаа.</p> <p>Тус өдөрлөгт орон нутгийн өмчит 11 компани, өмчийн оролцоотой 1 компаний, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар 5, төрийн өмчит 4 аж ахуйн нэгж, төрд бараа ажил үйлчилгээ нийлүүлэгч 11 аж ахуйн нэгж оролцов.</p>
-------	---	---

**Биелэлт гаргасан:**

Худалдан авах ажиллагааны хэлтсийн ахлах мэргэжилтэн

**Хянасан:**

Орон нутгийн өмчийн газрын дарга



Б.Болд

З.Гал-Эрдэнэ